



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/139/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 219

танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Б.МӨНГӨНЧИМЭГ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Булган сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520182

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Булган сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Мөнгөнчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нэмэлт данснаас гарсан зардлуудыг тооцооны дансаар дамжуулах талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална” гэж тодорхойлсон байна.

Булган сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах;
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь туслах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Булган сумын ЗДТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Булган сумын ЗДТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Axploger программ хангамж ашигладаг байна.

Булган сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Булган сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд 21 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 489,161.9 мянган төгрөгөөс тооцон 9,783.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,243.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймийн Булган сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 130,999.1 мянган төгрөгөөр буюу 16.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	433.9	433.9	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	148,958.7	148,988.7	30.0
Үндсэн хөрөнгө	818,320.9	1,016,470.0	198,149.1
Элэгдэл	-175,026.2	-242,206.2	-67,180.0
Нийт хөрөнгө	792,687.4	923,686.5	130,999.1
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	792,687.4	923,686.5	130,999.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	792,687.4	923,686.5	130,999.1

Авлага дансны үлдэгдэл нь өөрчлөгдөөгүй ч өмнөх онуудад бүртгэгдсэн 433.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь эзэн холбогдогч тодорхойгүй, авлага үүссэн анхан шатны баримт байхгүй байгаа тул аудитын дүгнэлтэд тусгаж өгсөн.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай бусад хангамжийн материалын дансанд хөрөнгө авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгө оруулалтаар болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө орлогод авсантай холбоотой байна. Хөрөнгө оруулалтаар 186,491.5 мянган төгрөг, өөрийн хөрөнгөөр 19,059.1 мянган төгрөгийн хөрөнгө авч нийт 205,550.6 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн байна. Тайлант онд ИТХ-ын шийдвэрээр 7,401.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 923,686.5 мянган төгрөг болж 130,999.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Булган сумын ЗДТГ нь тайлант онд 999.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 108.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 10,8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Өөрийн орлого	999,6	108,500	891,1	10,8
Нийт дүн				

Өөрийн орлого 891,1 мянган төгрөгөөр тасарсан нь төсвийн үндсэн дансанд орох байгаль орчны хог хаягдлын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар оруулж, зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 386,408.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 324,483.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 41,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 20,924.7 мянган төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламжид зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 385,408.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 999.6 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 226850,5 мянган төгрөг буюу 99,0 хувьтай байгаа нь боловсон хүчний нөөц дутуу байгаад цалингийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 62,551.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,858.5 мянган төгрөг, нийт 71,409.6 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс шүлхийн нөхөн олговорт 40,579.5 мянган төгрөг, хагас жилийн мал тооллого 406.0 мянган төгрөг, үлийн цагаан оготно устгал 14,320.0 мянган төгрөг, түймрээс хамгаалах БЗД, байгаль хамгаалагчийн зардал 536.5 мянган төгрөг, наадмын зардал 5,000.0 мянган төгрөг, түймрийн хохиролд 1,409.1 мянган төгрөг, урсгал болон гал түймрээс урьдчилан сэргийлэх зардалд 9,101.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 57,1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 21 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 75,746.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 202.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 66,066.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Цалин, томилолт, нэмэлт зардал, тээвэр шатахууны зардлуудыг ерөнхий журналаас түүвэрлэн авч шалгахад цалингийн зардлаас 202.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна. Энэ нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацаанд хийсэн 64,741,0 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Урьд онуудад бүртгэгдсэн эзэн холбогдолгүй 433.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа нь эзэн холбогдогч тодорхойгүй, авлага үүсгэсэн анхан шатны баримт байхгүй байгаа бөгөөд уг авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Төлөвлөсөн өөрийн үйл ажиллагааны орлогыг 891.1 мянган төгрөг буюу 89.1 хувиар дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нөөцийн сангийн зарцуулалттай холбоотой зөрчилд ЗДТГ-ын даргаас амралттай байх хугацаанд хийгдсэн, зарцуулах тухай захирамжийг төлөвлөөгүй гэсэн тайлбарыг ирүүлснийг үндэслэн сумын нэгтгэсэн тайланд Засаг даргын эрх хэмжээний асуудалд хамруулан шалгахгаар шийдвэрлэлээ. Мөн өөрийн орлогын төлөвлөгөө биелээгүй байхад дээд шатны төсөв захирагчаас орлогыг нэмэлт төсвөөр дамжуулан зарцуулах эрх өгсөн асуудлыг нэгтгэсэн тайланд хийх аудитаар шалгах шаардлагатай.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Булган сумын ЗДТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,534.0 төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг тайлант онд бүрэн барагдуулсан байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Булган сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Булган сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нэмэлт дансны зардлын талаар

1.1. Илрүүлэлт: Нэмэлт данснаас зарцуулсан зардлуудыг түүвэрлэн авч шалгахад 9,478.6 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй зарцуулсан байна.

1.2. Эрсдэл: Тооцооны алдаа үүсэж, тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	149392686.74	149422686.74
33	АВЛАГА	433988.00	433988.00
335	Бусад авлага	433988.00	433988.00
3351	Байгууллагаас авах авлага	433988.00	433988.00
35	БАРАА МАТЕРИАЛ	148958698.74	148988698.74
354	Хангамжийн материал	25175774.74	25205774.74
35420	Аж ахуйн материал	5349973.74	5349973.74
35430	Сэлбэг хэрэгсэл	1000000.00	1000000.00
35470	Бусад хангамжийн материал	18825801.00	18855801.00
35600	Мал амьтад	123782924.00	123782924.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	643294749.61	774263817.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	643294749.61	774263817.88
392	Биет хөрөнгө	636911149.61	767101017.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	385893690.61	464678190.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2765780.89	-8989391.17
39203	Авто-тээврийн хэрэгсэл	93535824.00	108085824.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25632813.37	-59772624.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81181118.05	92858818.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46065963.94	-51631048.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55678834.00	55426484.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29408408.25	-31711677.40
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1339400.00	1339400.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-1339400.00	-1339400.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	192954532.33	285411481.33
39215	Хуримтлагдсан элэгдэл	-68459882.93	-87255039.13
393	Биет бус хөрөнгө	6383600.00	7162800.00
39301	Програм хангамж	1966000.00	2898200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1354000.00	-1507000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5771600.00	5771600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	792687436.35	923686504.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	792687436.35	923686504.62
51	Засгийн газрын хувь оролцоо	792687436.35	923686504.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	581162917.26	581162917.26
51101	Өмч: - төрийн	581162917.26	581162917.26
512	Хуримтлагдсан үр дүн	103258436.38	234257504.65
51210	Өмнөх үеийн үр дүн	103258436.38	103258436.38
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	130999068.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108266082.71	108266082.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	792687436.35	923686504.62

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	411850446.00	643186423.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56029000.00	186599949.00
120	Нийтлэг татварын бус орлого	56029000.00	186599949.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56029000.00	186599949.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	108500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56029000.00	186491449.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	355821446.00	456586474.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69180746.00	71409574.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52318080.00	61141989.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14862666.00	10267585.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	286640700.00	385176900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	286640700.00	385176900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	772035129.75	510608069.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	758729129.75	485408069.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	751359862.40	437517996.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194715543.88	214649838.64
210101	Үндсэн цалин	194715543.88	214649838.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	441508657.08	26770011.00
210201	Тэтгэврийн даатгал	16087598.12	17526811.00
210202	Тэтгэмжийн даатгал	16164999.54	1848600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2019398.14	2310800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	403198063.00	462300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4038598.28	4621500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4820777.00	4735333.00
210301	Гэрэл, цахилгаан	2372187.00	1448689.00
210302	Түлш, халаалт	2448590.00	3087644.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	199000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12702213.40	26604852.00
210401	Бичиг хэрэг	2059685.00	5846550.00
210402	Тээвэр, шатахуун	7675866.00	15895792.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2966662.40	3525000.00
210404	Ном, хэвлэл	0.00	303500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	184010.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	850000.00
2105	Нормативт зардал	300000.00	1525000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000.00	1525000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	999900.00	4225000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	299900.00
210604	Урсгал засвар	999900.00	3925100.00
2107	Томилолт, зочны зардал	2690000.00	7875500.00
210702	Дотоод албан томилолт	2690000.00	7875500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1401544.00	2693492.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	749088.00	88000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	600000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118800.00	285000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193656.00	245492.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50000.00	77000.00
210807	Газрын төлбөр	0.00	1398000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92221227.04	148438969.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43350908.00	75436774.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48870319.04	73002195.49

Булган сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7369267.35	47890073.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	15984700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	14284700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1700000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7369267.35	31905373.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7369267.35	31905373.36
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13306000.00	25200000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13306000.00	25200000.00
223001	Бусад хөрөнгө	13306000.00	25200000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-360184683.75	132578353.51
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17407306.31	1579285.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	1579285.24
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-17407306.31	-1579285.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-377591990.06	130999068.27

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	355821446.00	456694974.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	108500.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	108500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	108500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	108500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	355821446.00	456586474.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69180746.00	71409574.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52318080.00	61141989.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14862666.00	10267585.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	286640700.00	385176900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	286640700.00	385176900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	292515446.00	428594974.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292515446.00	428594974.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285146178.65	380704900.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194715543.54	214649838.64
210101	Үндсэн цалин	194715543.54	214649838.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24165292.71	26770011.00
210201	Тэтгэврийн даатгал	16087598.12	17526811.00
210202	Тэтгэмжийн даатгал	1616499.54	1848600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2019398.14	2310800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	403198.63	462300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4038598.28	4621500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4358067.00	4570909.00
210301	Гэрэл, цахилгаан	2372187.00	1448689.00
210302	Түлш, халаалт	1985880.00	2923220.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	199000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13364923.40	25985976.00
210401	Бичиг хэрэг	1899105.00	5175020.00
210402	Тээвэр, шатахуун	8499156.00	15656656.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2966662.40	3525000.00
210404	Ном, хэвлэл	0.00	303500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	275900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1049900.00
2105	Нормативт зардал	300000.00	1525000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000.00	1525000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	999900.00	12700000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	8644900.00
210604	Урсгал засвар	999900.00	4055100.00
2107	Томилолт, зочны зардал	2690000.00	7875500.00
210702	Дотоод албан томилолт	2690000.00	7875500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1401544.00	10207692.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	749088.00	88000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	600000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118800.00	285000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193656.00	245492.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50000.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	290000.00	7514200.00
210807	Газрын төлбөр	0.00	1398000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43150908.00	76419974.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43150908.00	76419974.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7369267.35	47890073.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	15984700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	14284700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1700000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7369267.35	31905373.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7369267.35	31905373.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	63306000.00	28100000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63306000.00	28100000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63306000.00	28100000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63306000.00	28100000.00
223001	Бусад хөрөнгө	53306000.00	28100000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-63306000.00	-28100000.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	103,258,436.38	0.00	792,687,436.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	103,258,436.38	0.00	792,687,436.35
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	103,258,436.38	0.00	792,687,436.35
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	103,258,436.38	0.00	792,687,436.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	103,258,436.38	0.00	792,687,436.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	130,999,068.27	0.00	130,999,068.27
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	234,257,504.65	0.00	923,686,504.62

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	287640700,00	279271432,65	386408400,00	325280026,64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259088800,00	250965432,65	345408400,00	325280026,64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259088800,00	250965432,65	329383700,00	309295326,64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201921700,00	194715543,54	231289500,00	214649838,64
210101	Үндсэн цалин	201921700,00	194715543,54	231289500,00	214649838,64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24164300,00	24165292,71	28885400,00	26770011,00
210201	Тэтгэврийн даатгал	16086600,00	16087598,12	19642200,00	17526811,00
210202	Тэтгэмжийн даатгал	1616500,00	1616499,54	1848600,00	1848600,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2019400,00	2019398,14	2310800,00	2310800,00
210204	Ажилгүйдлийн даатгал	403200,00	403198,63	462300,00	462300,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4038600,00	4038598,28	4621500,00	4621500,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5000000,00	4358067,00	5286000,00	4570909,00
210301	Гэрэл, цахилгаан	2000000,00	2372187,00	2160000,00	1448689,00
210302	Түлш, халаалт	3000000,00	1985880,00	2926000,00	2923220,00
210303	Цэвэр, бохир ус	0,00	0,00	200000,00	199000,00
210304	Байрны түрээс				
2104	Хангамж, бараа материалын зардал	12474800,00	12464923,40	26378400,00	25985976,00
210401	Бичиг хэрэг	1900000,00	1899105,00	5177800,00	5175020,00
210402	Тээвэр, шатахуун	7600000,00	7599156,00	15656700,00	15656656,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2974800,00	2966662,40	3620000,00	3525000,00
210404	Ном, хэвлэл		0,00	378000,00	303500,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0,00	0,00	275900,00	275900,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0,00	0,00	1270000,00	1049900,00
2105	Нормативт зардал	300000,00	300000,00	1525600,00	1525000,00
210502	Хоол, хүнс				
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000,00	300000,00	1525600,00	1525000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1000000,00	999900,00	12818100,00	12700000,00

Булган сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	0,00	0,00	8650000,00	8644900,00
210602	Тавилга	0,00	0,00	331800,00	0,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл				
210604	Урсгал засвар	1000000,00	999900,00	3836300,00	4055100,00
2107	Томилолт, зочны зардал	2834000,00	2690000,00	7986500,00	7875500,00
210701	Гадаад албан томиллолт				
210702	Дотоод албан томиллолт	2834000,00	2690000,00	7986500,00	7875500,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	774000,00	652456,00	10214200,00	10207692,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0,00	0,00	88000,00	88000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120000,00	0,00	600000,00	600000,00
210803	Даатгалын үйлчилгээ	120000,00	118800,00	285000,00	285000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194000,00	193656,00	250000,00	245492,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50000,00	50000,00	77000,00	77000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	290000,00	290000,00	7514200,00	7514200,00
210807	Газрын төлбөр	0,00	0,00	1400000,00	1398000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10620000,00	10619250,00	5000000,00	5010400,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10620000,00	10619250,00	5000000,00	5010400,00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0,00	0,00	16024700,00	15984700,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0,00	0,00	16024700,00	15984700,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0,0	0,0	1740000,00	0,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0,0	0,0	0,00	14284700,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0,0	0,0	14284700,00	1700000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28551900,0	28306000,0	41000000,0	0,0
2200	Дотоод эх үүсвэрээр	28551900,0	28306000,0	41000000,0	0,0
223001	Бусад хөрөнгө	28551900,0	28306000,0	41000000,00	0,00
224001	Стратегийн нөөц хөрөнгө				
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	287640700,00	279271432,65	386408000,00	385516900,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	287640700,00	279271432,65	0,00	0,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	286640700,00	279271432,65	385408400,00	385408400,00
132001	Орон нутгийн төсвөөс	286640700,0	279271432,7	385408400,00	385408400,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1000000,00	0,00	999600,00	108500,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1000000,0		999600,00	108500,00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих				
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			0,00	0,00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0,0	0,0	0,00	0,00

